



ГААЛИЙН ЕРӨНХИЙ ГАЗАР  
ДОРНОГОВЬ АЙМГИЙН ЗАМЫН-ҮҮД СУМ  
ЗАМЫН-ҮҮД ГААЛИЙН ГАЗРЫН  
ДАРГЫН ТУШААЛ

2024 оны 06 сарын 07 өдөр

Дугаар А/54

Замын-Үүд сум

Ёс зүй, үйлчилгээний стандартын хэрэгжилтийг  
хангуулах тухай

Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.2, 7.1.7, 7.1.8, 8 дугаар зүйлийн 8.1.1, 8.1.2, 8.1.3, 8.2.1, 8.2.3, 8.2.6, 12 дугаар зүйлийн 12.1.1, 12.1.2 дахь заалт, Гаалийн тухай хуулийн 269<sup>1</sup> дүгээр зүйлийн 269<sup>1</sup>1.1, 269<sup>1</sup>1.8 дахь заалт, Улсын Их Хурлын 2024 оны 27 дугаар тогтоолоор батлагдсан "Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үндэсний хөтөлбөр"-ийн 1.4 дэх зорилтын 1.4.1 дэх заалт, Гаалийн ерөнхий газрын даргын 2009 оны 534 дүгээр тушаалаар батлагдсан "Гаалийн улсын байцаагчийн ёс зүйн дүрэм", 2021 оны А/251 дүгээр тушаалаар батлагдсан "Гаалийн улсын байцаагчийн дүрэмт хувцас, ялгах тэмдэг хэрэглэх журам"-ын 3 дугаар зүйлийн 3.2, 4 дүгээр зүйлийн 4.14, 5 дугаар зүйлийн 5.1, 5.2, 5.3, 5.4, 5.5 дахь хэсэг, 6 дугаар зүйл, 7 дугаар зүйлийн 7.3 дахь хэсэг, 2016 оны А/69 дүгээр тушаалаар батлагдсан "Гаалийн улсын байцаагчийн үйлчилгээний стандартын журам"-ын 8 дугаар зүйлийн 8.1, 8.2 дахь хэсэг, 2022 оны А/226 дугаар тушаалаар батлагдсан "Гаалийн байгууллагын хөдөлмөрийн дотоод журам"-ын 2 дугаар зүйлийн 2.9.1, 3 дугаар зүйлийн 3.1.4, 7 дугаар зүйлийн 7.1 дэх хэсэг, 2019 оны А/142 дугаар тушаалаар батлагдсан "Гаалийн ерөнхий газрын харьяа гаалийн газар, хорооны дүрэм"-ийн 4 дүгээр зүйлийн 4.3.2, 4.3.4 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. "Гаалийн улсын байцаагчийн ажлын байранд хэрэглэх дүрэмт хувцасны стандарт"-ыг нэгдүгээр хавсралтаар, "Гаалийн улсын байцаагчийн албан ажлын үед мөрдөх харилцааны стандарт"-ыг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Гаалийн хяналтын бүсүүдэд хуваарилагдан ажиллаж буй гаалийн улсын байцаагч нарт дүрэмт хувцасны болон харилцааны стандартыг танилцуулж, өдөр тутам мөрдүүлж, хяналт тавихыг гаалийн хяналтын бүс хариуцсан гаалийн улсын ахлах байцаагч нарт, хариуцлага тооцож ажиллахыг Зөрчилтэй тэмцэх албаны дарга (Б.Ундрах)-д тус тус үүрэг болгосугай.

3. Тушаалын хэрэгжилтийг зохион байгуулж удирдлагаар хангах, хяналт тавьж хариуцлага тооцож ажиллахыг Захиргааны албаны дарга (Э.Чулуунбаатар), Хяналт, шалгалтын албаны дарга (Г.Алтансүх), Бүрдүүлэлтийн албаны дарга (Ж.Цолмон), Зөрчилтэй тэмцэх албаны дарга (Б.Ундрах), Эрсдэлийн удирдлагын

44 24 01 051

албаны даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч (Н.Төрсайхан), Хорио цээрийн албаны Мал эмнэлэг, ургамлын хорио цээрийн хяналт хариуцсан гаалийн улсын ахлах байцаагч (С.Солонго), Санхүү, аж ахуйн албаны дарга бөгөөд ерөнхий нягтлан бодогчийн албан үүргийг түр орлон гүйцэтгэгч (Г.Удвалмядаг) -д тус тус даалгасугай.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ  
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ



О.ЦЭЭНРЭГЗЭН